

МОНГОЛ УЛСЫН  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр  
сарын 11-ны өдөр

№ 96

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Компаний тухай хуулийн 93.1, 94.2, 94.3.4 дэх заалт, Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн санхүүгийн тайланд хавсаргах нэмэлт тайлбар, тодруулга, санхүүгийн шинжилгээний тухай журам ”-ыг хавсралтад дурдсанаар баталсугай.
2. Жилийн санхүүгийн тайлангийн хамт энэ журмын дагуу нэмэлт тайлбар, тодруулга гарган ирүүлж байхыг хувьцаат компаниудын удирдлагад үүрэг болгосугай.
3. Хувьцаат компаниудын санхүүгийн тайланд энэ журмын дагуу шинжилгээ хийж, тухайн оны эхний хагас жилд багтаан Хороонд ирүүлж байхыг Монголын хөрөнгийн биржийн удирдлага (О.Батбилэг)-д даалгасугай.
4. Журмын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Ж.Жадамбаа)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

Үнэт цаасны хорооны 1999 оны 11 дүгээр сарын  
11-ний өдрийн 96 дугаар тогтоолын хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХАВСАРГАХ НЭМЭЛТ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА,  
САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Үнэт цаасаа Хороо болон хөрөнгийн биржид бүртгүүлж, нийтэд санал болгон арилжаалж байгаа компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг харуулах тайлан балансын үзүүлэлтийг дэлгэрэнгүй болгох үүднээс нэмэлт тодотгол тайлбартай гаргуулах, санхүүгийн үзүүлэлтийг ашиглан компанийн санхүүгийн чадварыг тодорхойлон хөрөнгө оруулагчид болон хувь нийлүүлэгчдэд бодитой, хангалттай мэдээллийг хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Хороо болон хөрөнгийн биржид ирүүлэх хагас жил, жилийн эцсийн тайланг энэхүү журмын дагуу нэмэлт тайлбар, тодруулгатай ирүүлж байна.

3. Санхүүгийн тайланг нэмэлт тайлбар, тодруулгын хамт хариуцсан мэргэжилтэн (ажилтан) хянаж хүлээн аваад хуудас тус бүрд “Бүртгэв” тэмдгийг дарж компанийн хавтаст хадгална.

4. Санхүүгийн тайланг аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан байна.

5. Хувьцаат компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээг компанийн талаарх мэдээллийн сан болох хувийн хэрэгт хавсаргана.

6. Хувьцаат компанийн жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтийг үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдсэн салбар чиглэлээр нь нэгтгэж, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх санхүүгийн харьцааны шинжилгээг хийж дүгнэлт гаргана.

7. Хөрөнгийн биржийн Бүртгэл судалгааны алба компанийн жилийн эцсийн тайлан тэнцэлд тулгуурлан дээрх шинжилгээг хийж санхүүгийн жил дууссаны дараа оны эхний хагас жилд багтаан гаргаж Хороонд ирүүлнэ.

8. Салбараар гаргасан дээрх санхүүгийн шинжилгээ, дүгнэлтийг тусгай хавтас нээж хадгална.

9. Тухайн компанид хөрөнгө оруулах сонирхолтой этгээд, үнэт цаас эзэмшигчид компанийн хувийн хэрэг болон санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт мэдээллийг танилцуулж болно. Харин хуулбарлан авах бол түүнтэй холбогдсон зардлыг сонирхогч этгээд хариуцна.

ХОЁР. Санхүүгийн тайланд хавсаргах  
нэмэлт тайлбар, тодруулга

1. Үнэт цаас гаргагч санхүүгийн тайлангийн нэмэлт тодотгол, тайлбарыг энэ журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу гаргаж Хороонд ирүүлнэ.

2. 1 дүгээр хавсралтад нэгтгэсэн тайлангийн тодотголд шаардлагатай нэмэлт үзүүлэлтийн эдийн засгийн утга, ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлно.

2.1. **Авлага.** Энд бараа бүтээгдэхүүн борлуулж, ажил үйлчилгээ үзүүлсэн үндсэн баримтыг үндэслэн худалдан авагч, захиалагчаас авахаар тооцоолсон авлагын мөнгөн дүнг үзүүлнэ. Авлага нь хугацаагаараа богино, урт хугацаатай гэж хуваагдана.

Нэг жилийн дотор төлөгдөх авлагыг богино хугацаатай авлагад тооцож ангилна. Үүнийг эргэлтийн хөрөнгөд хамааруулна. Түүнээс дээшхи хугацааны авлагыг урт хугацаатай авлага гэх буюу эргэлтийн бус хөрөнгөд хамааруулна.

а) **найдваргүй авлага** . Нэхэмжлэх эзэнгүй болох, төлбөр хариуцагч дампуурах зэрэг авлагыг найдваргүйд тооцон дансаас хасдаг. Найдваргүй авлагын нөөцийг төлөгдөөгүй байгаа авлагын дүн болон борлуулалтын орлогын дүнгээс тооцно.

б) **найдвартай авлага.** Нийт авлагын дүнгээс найдваргүй авлагын нөөцийг хасаж, цэвэр авлагын хэмжээгээр тодорхойлогдоно. Энд векселийн авлага болон бусад хугацаа хэтрээгүй авлага хамаарна.

2.1.1. **Байгууллагаас авах авлага.** Энд тухайн компанийн бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, гадаад дотоодын байгууллага болон уялдаа холбоо (толгой, охин, хараат компани) бүхий компаниудаас авах үндсэн борлуулалтын болон ажил үйлчилгээний авлагыг хамааруулан бүртгэнэ.

2.1.2. **Хувь хүмүүсээс авах авлага.** Энд өөрийн компанийн ажилчин, албан хаагчдад (хавсралтад ААХ гэнэ), бусад бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчдад боролуулсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлсний төлөө, бэлэн мөнгөөр зээл өгөх зэргээр эргэж төлөгдөх журмаар баримтыг үндэслэн захиалагч, зээлдэгчээс авах авлага орно.

2.1.3. **Төсвөөс авах авлага.** Энд байгууллагын орлогын албан татвар, суутган тооцсон татвар (хүн амын орлогын албан татварыг хэлнэ), нэмүү өртгийн татвар, даатгалд төлөх шимтгэл зэргийг урьдчилж төлсөн тохиолдолд төсөвтэй хийх тооцоо гардаг.

2.1.4. **Векселийн авлага.** Энэ нь төлбөр гүйцэтгэх хугацаа дуусмагц төлбөр нэхэх эрхийг нэхэмжлэгчид олгосон баримт дахь авлага юм. Векселд дараах зүйлийг тусгасан байна:

- а) векселийн үндсэн байгууллага, хугацаа ;
- б) өрийн мөнгөн дүн ;
- в) төлбөр гүйцэтгэх байгууллага, хугацаа ;
- г) өр нэхэмжлэгчийн нэр.

2.1.5. **Бусад авлага.** Энд хүү, торгууль болон ногдол ашиг, түрээсийн гэх мэт авлага хамрах бөгөөд 1 дүгээр хавсралтын “Өр авлагын нэмэгдэл тооцоо судалгаа”-нд тус бүрээр нь салгаж бичнэ.

2.2. Бизнесийн үйл ажиллагааны явцад үүссэн бусдын өмнө хүлээх санхүүгийн хариуцлагыг өр төлбөр гэнэ.

Өр төлбөрийг төлөх хугацаагаар нь дараах байдлаар хуваана:

- а) нэг жилийн дотор буюу бизнесийн үйл ажиллагааны нэг мөчлөгийн дотор төлөх төлбөрийг богино хугацаатай ;
- б) нэг жилээс дээш хугацаанд төлөх өр төлбөрийг урт хугацаатай өр төлбөр гэж ангилан бүртгэж тайланд тусгана.

2.2.1. Байгууллагад өгөх өглөгт бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч болон дотоод гадаадын байгууллагаас худалдан авсан бараа, материал, үзүүлсэн ажил үйлчилгээний үнээ дараа төлөхөөр тооцоо үүсгэсэн үед үүсэх өр төлбөрт хамаарна.

2.2.2. **Хүмүүст өгөх өглөг.** Энд өөрийн компанийн ажилчин , албан хаагч (хавсралтад ААХ гэсэн), бусад бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчаас худалдан авсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээний үнийг дараа төлөхөөр үүссэн тооцоо, мөн ажилчдад олгох цалингийн өглөг зэргийг хамааруулна.

2.2.3. **Төсөвт төлөх төлбөр.** Энд нийгмийн даатгал, байгууллагын орлогын албан татвар, худалдааны татвар, суутган тооцсон татвар (хүн амын орлогын албан татвар) зэрэг нь ногдох хэмжээгээрээ хамаарагдана.

2.2.4. **Векселийн өглөг.** Худалдан авах бараа материалын үнийг төлөх тухайгаа баталж баримт бичиг гарган төлбөр тооцоо хийхийг хэлнэ. Вексель нь хүүтэй ба хүү тооцохгүй байж болно.

2.2.5. **Банкны богино хугацаатай зээлийн өр.** Эргэлтийн хөрөнгийг эх үүсвэр дутагдалтай үед арилжааны банкнаас нэг жилээс доош хугацаагаар авсан зээлийг оруулна.

2.2.6. **Урьдчилж төлөгдсөн өр.** Гэрээний дагуу бараа үйлчилгээгээ худалдан авагчдад нийлүүлэхээс өмнө түүний үнийг урьдчилан төлсөн бол жинхэнэ хэрэгжилтийн зарчмын дагуу өр болгож бүртгэнэ.

2.2.7. **Бусад өглөг.** Энд хүү, торгуулийн өглөгийг хамруулан тус тусад нь бүртгэнэ.

3. 2 дугаар хавсралтад нэгтгэх хөрөнгө оруулалт, зээлийн судалгаанд шаардлагатай нэмэлт зарим үзүүлэлтийн эдийн засгийн утга, ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлно.

3.1. Урт хугацаатай хөрөнгө оруулалт гэдэг нь бизнесийн дотоод эргэлтэд ашиглагдахгүй илүүдэж байгаа мөнгөн хөрөнгийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглаж, аль нэг хэлбэрээр ашигтай эргэлтэд оруулах үйл ажиллагаа юм. Энд 2 дугаар хавсралтын 1 дэх хөрөнгө оруулалтын хэлбэрүүд хамаарна.

3.2. Тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан илүүдэл мөнгөн хөрөнгөө ашиг олох зорилгоор зарцуулж байгаа үйл ажиллагааг богино хугацаатай хөрөнгө оруулалт гэнэ. Энд хугацаатай хадгаламж, түргэн борлогдох үнэт үнэт цаас, урт хугацаатай хөрөнгө оруулалтын тайлант үед ногдох зүйлийг санхүүжүүлэх хэсгийг хамааруулна.

3.3. Үнэт цаас гаргагчийн зээлийн судалгааг хугацаагаар нь ангилж баланс дээр тусгагдсан зээлийн нийт хэмжээнээс тооцож 2 дугаар Б хавсралтад тусгана.

## ГУРАВ. Бусад нэмэлт мэдээлэл

1. Хувьцаат компани нь Компанийн тухай хуулийн 6.3, 6.4 дэх заалтын дагуу үргэлжилсэн гинжин холбоо бүхий толгой, охин, хараат компанитай бол тэдгээрийн хоорондын өр, авлагын тооцоо, тэдгээрт оруулсан хөрөнгийн талаар нэмэлт тайлбар гаргана.

2. Хэрэв толгой компани охин болон хараат компанитай байгуулсан гэрээндээ тэдний өрийг хариуцахаар заасан бол уг өрийг балансынхаа өр төлбөрт оруулж тусгаад энэ талаар тайлбар гаргана.

3. Компани гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авсан бол үлдэгдэл балансын пассив буюу хөрөнгийн эх үүсвэрийн “халаасны хувьцаа” гэсэн үзүүлэлт болон мөнгөн гүйлгээний тайлан (СТ-4)-гийн 3-ын 7-д бичиж, хувьцаа худалдан авах шийдвэрийн нэр, огноо, дугаар, худалдан авсан хувьцааны тоо, нэгжийн дундаж үнэ, зориулалт зэргийн талаар нэмэлт тайлбар гаргана.

4. Компани нэгдсэн, нийлсэн, хуваагдсан, тусгаарлагдсан тохиолдолд төсөлд тусгасан үнэт цаасыг бусад хөрөнгөнд болон шинээр үүссэн компанийн үнэт цаасанд хөрвүүлсэн талаар нэмэлт тайлбарт тусгасан байна.

5. Компанийн өрийг хувьцаагаар солих үед өрийг хувьцаагаар сольсон нөхцлийг нэмэлт тайлбарт тодруулсан байна.

6. Компанийн тухай хуулийн 34.2-т заасны дагуу гаргасан хувьцааны тоог компанийн балансад төрөл тус бүрээр нь тусгаж, зарласан хувьцаа, түүнээс гаргасан хувьцааны төрөл, хэлбэр, үнийн талаар 1 дүгээр хавсралтад тусгана.

7. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж балансын пассивт хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү гэсэн зүйл тусгасан бол үнэлгээ хийсэн компанийн нэр, хийлгэсэн үнэлгээний арга зэргийн талаар нэмэлт мэдээлэл гаргана.

8. Компанийн ТУЗ нь хувь нийлүүлэгч нарт зориулан тайлангийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаарх тайлан илтгэлийг бичиж санхүүгийн тайланд хавсаргаж ирүүлнэ.

9. Мөн компанийн дүрмээр тогтоосон зарим мэдээллийн талаарх тодруулга хавсаргана.

10. хувь нийлүүлэгчдийн хурлаар ногдол ашгийг Хөрөнгийн бирж болон Үнэт цаасны компаниар дамжуулан тараах, эсхүл биет хэлбэрээр компани дээрээ өгөхөөр тогтсон бол холбогдох шийдвэр, баримт бичгийн хуулбарыг ирүүлнэ.

## ДӨРӨВ. Компанийн санхүүгийн шинжилгээ

1. Компанийн санхүүгийн шинжилгээг хувьцаат компаниудын санхүүгийн чадварыг тодорхойлох, ялангуяа хөрөнгө оруулагчид шаардлагатай санхүүгийн харьцааны шинжилгээг нэгтгэхэд чиглэнэ. Журмын уг хэсгийг Биржийн бүртгэл, судалгааны алба компанийн жилийн эцсийн тайлан тэнцэлд тулгуурлан гаргаж байна.

## 2. Шинжилгээнд дараах харьцаануудыг хамааруулна.

2.1. Хөрвөх чадварын харьцаа (K1): Эргэлтийн хөрөнгийн харьцаа, түргэн хөрвөх чадвар;

2.2. Хөшүүргийн харьцаа (K2): Өр төлбөрийн харьцаа, өр нийт хөрөнгийн харьцаа;

2.3. Үйл ажиллагааны харьцаа (K3): Бараа материалын эргэц, үндсэн хөрөнгийн эргэц, нийт хөрөнгийн эргэц;

2.4. Ашигт ажиллагааны харьцаа (K4) : нийт хөрөнгийн өгөөж, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн өгөөж;

2.5. Ногдол ашиг төлбөрийн харьцаа (K5): ногдол ашгийн өгөөж, нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг;

2.6. Хувьцааны зах зээлийн үнэлгээ (K6): Нэгж хувьцааны бүртгэлийн үнэ, нэгж хувьцааны зах зээлийн үнийн харьцаа

3. Дээрх итгэлцүүрийн эдийн засгийн арга, ач холбогдол нь дараах утгыг агуулна:

K1-a) хөрвөх чадварын харьцааг уг компанийн мөнгөн хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгийг богино хугацаатай өр төлбөрт харьцуулна.

б) түргэн хөрвөх чадварын харьцаа нийт эргэлтийн хөрөнгөөс бараа материалыг хасаад эргэлтийн өр төлбөрт хуваасантай тэнцүү байна. K1 нь тухайн компани эргэлтийн өр төлбөрийг ямар хугацаанд эргэж төлж чадах боломжийг харуулна.

K2-a) нийт өр нийт хөрөнгийн харьцаа нь өрийн харьцаагаар тодорхойлогдоно. Нийт өр төлбөрийн харьцаа нь компанийн нийт нийт өрийг нийт активт харьцуулна.

K2 нь нийт хөрөнгийн хэдэн хувь нь зээлийн эх үүсвэрээр бий болсныг харуулна.

K3-a) Бараа материалын эргэцийн харьцаа нь борлуулалтын дүнг бараа материалд харьцуулах харьцаа;

б) үндсэн хөрөнгийн эргэц нь борлуулалтын хэмжээг үндсэн хөрөнгийн дүнд харьцуулах харьцаа;

в) нийт хөрөнгийн эргэц нь борлуулалтын хэмжээг нийт хөрөнгийн хэмжээнд харьцуулах харьцаа.

K3 нь компанийн удирдлагын үйл ажиллагааны идэвхжил, хөрөнгөө хэр зэрэг үр ашигтай зарцуулж буйг тодорхойлж өгнө.

K4-a) нийт хөрөнгийн өгөөж цэвэр ашгийг (татвар төлсний дараах ашиг) нийт хөрөнгийн хэмжээнд харьцуулах харьцаа;

б) хувь нийлүүлэгчдийн (эзэмшигчид) өмчийн харьцааг цэвэр ашгийг (татвар төлсний дараах ашиг) нийт хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн хэмжээнд харьцуулна.

К4 нь компанийн хувь нийлүүлэгчдэд өөрийн оруулсан хөрөнгийн хэмжээ хэрхэн үр ашигтай зарцуулагдаж байгаа, үйл ажиллагааны цэвэр ашгийн хичнээн хувийг хувь нийлүүлэгчдэд очиж буйг харуулах үзүүлэлт юм.

К5-а) нэгж хувьцааны ашгийг тодорхойлоход цэвэр ашгийг нийт гаргасан хувьцааны тоонд харьцуулах замаар тодорхойлно.

б) нэгж хувьцааны ногдол ашгийг ногдол ашигт хуваарилсан цэвэр ашгийн дүнг гаргасан хувьцааны тоонд харьцуулж гаргана.

К5 харьцаа нь компанийн ногдол ашиг төлөлтийн байдлыг тодорхойлох бөгөөд хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагчдад ихээхэн ач холбогдолтой.

К6-а) нэгж хувьцааны бүртгэлийн үнийг хувьцаа гаргасан хөрөнгийн хэмжээнд харьцуулна.

б) нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь компанийн зах зээлд арилжаалагдаж байгаа хувьцааны үнийг бүртгэлийн үнэд харьцуулна.

К6 нь компанийн энгийн хувьцааны зах зээлийн үнэлгээний өөрчлөлтийг тодорхой хугацаанд хэрхэн өөрчлөгдөж буйг харуулна. Уг коэффициентийг тодорхойлоход нэгж хувьцааны бүртгэлийн үнийг хувь нийлүүлэгчдийн өмчийн дүнг борлуулсан хувьцааны тоонд харьцуулах замаар шийдвэрлэнэ.

4. Дээрх харьцаануудыг журмын 1-ийн 6 дахь хэсэгт зааснаар 3 дугаар хавсралтаар гаргаж ирүүлнэ.

5. 3 дугаар хавсралтын дүгнэлт, тайлбар гэсэн хэсэгт компанийн санхүүгийн харьцааг тухайн салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулан дунджаас бага, дундаж, дунджаас их аль нь болохыг тэмдэглэнэ.

6. Дээрх хавсралтад дурдсан үзүүлэлтийг үнэн зөв, бодитой гаргаж ирүүлэхийг үнэт цаас гаргагч компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн менежер нар хариуцна.

200. оны ..-р сар  
ӨР АВЛАГЫН НЭМЭГДЭЛ ТООЦОО, СУДАЛГАА

2.1. Нийт авлага		Дүн
а	Найдвартай авлага	
б	Найдваргүй авлага	
2.1.1. Байгууллагаас авах авлага		
А	Бэлтгэн нийлүүлэгчээс	
Б	Худалдан авагчаас	
В	Толгой компаниас	
Г	Хараат компаниас	
Д	Охин компаниас	
Е	Гадаадын байгууллагаас	
2.1.2. Хүмүүсээс авах авлага		
А	Өөрийн компанийн ААХ-аас. Үүнээс: Эрх бүхий албан тушаалтнаас	
Б	Бусад хүмүүсээс	
2.1.3. Төсвөөс авах авлага		
А	Нэмүү өртгийн татвар	
Б	Байгууллагын орлогын татвар	
В	Суутган тооцсон татвар	
Г	Даатгалын авлага	
2.1.4. Векселийн авлага		
2.1.5. Бусад авлага		
А	Хүү торгуулийн авлага	
Б	Ногдол ашгийн авлага	

2.2. Нийт өр төлбөр		
А	Богино хугацаатай өглөг	
Б	Урт хугацаатай өглөг	
2.2.1. Байгууллагад өгөх өглөг		
А	Бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид	
Б	Толгой компанид	
В	Хараат компанид	
Г	Охин компанид	
Д	Бусад байгууллагад	
Е	Гадаадын байгууллагад	
2.2.2. Хүмүүст өгөх өглөг		
А	Цалингийн өглөг	
Б	Өөрийн компанийн ААХ-д	
В	Бусад хүмүүст	
2.2.3. Төсөвт төлөх төлбөр		
А	Нэмүү өртгийн татвар	
Б	Байгууллагын орлогын татвар	



В	Суутган тооцсон татвар	
Г	Даатгалын өглөг	
	2.2.4. Векселийн өглөг	
А	Хүү тооцсон өглөг	
Б	Хүү тооцоогүй өглөг (хөнгөлөлт үзүүлнэ)	
	2.2.5. Банкны богино хугацаатай зээлийн өр	
	2.2.6. Урьдчилж төлөгдсөн	
А	Түрээсийн өглөг	
Б	Хүү торгуулийн өглөг	
В	Ногдол ашгийн өглөг	
	2.2.7. Бусад өглөг	

**А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУДАЛГАА**

3.1. Урт хугацаатай хөрөнгө оруулалт		
А	Үндсэн хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт	
Б	Давуу эрхийн болон энгийн хувьцааны хөрөнгө оруулалт	
В	Бонд, барьцаалсан хөрөнгөөрх хөрөнгө оруулалт	
Г	Сан хөмрөгөөрхи хөрөнгө оруулалт	
Д	Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан	Үнэт цаасны нэр
		Үнэт цаасны төрөл
		Гаргасан үнэт цаасны нэрлэсэн үнэ
		Гаргасан хувьцааны тоо
		Нийт үнийн дүн
		Хөрөнгө оруулалтын зориулалт
3.2. Богино хугацаатай хөрөнгө оруулалт		
А	Хугацаатай хадгаламж	
Б	Түргэн борлогдох үнэт цаас	Үнэт цаас гаргасан компанийн нэр
		Нэр төрөл
		Тоо хэмжээ
		Худалдаж авсан үнэ
		Тухайн үеийн ханш
		Өрийн бичиг авсан бол эргэн төлөгдөх хугацаа
		Худалдаж авсан зорилго
В	Урт хугацаатай хөрөнгө оруулалтын тайлант үед ногдох хэсгийг санхүүжүүлэх	

**Б. ЗЭЭЛИЙН СУДАЛГАА**

3.3. Богино хугацаатай зээл		Дүн
А	Зээл олгосон банкны нэр	
Б	Зээлийн хэмжээ (төгрөг)	
В	Зээлийн хүүгийн хувь (сарын)	
Г	Зээлийн хугацаа (сар)	
Д	Хугацаанд төлөгдсөн зээл	
Е	Хугацаа хэтэрсэн зээлийн дүн	
3.4. Урт хугацаатай зээл		
А	Зээл олгосон банкны нэр	
Б	Зээлийн хэмжээ (төгрөг)	
В	Зээлийн хүүгийн хувь (сарын)	
Г	Зээлийн хугацаа (жил)	
Д	Хугацаанд төлөгдсөн зээл	
Е	Хугацаа хэтэрсэн зээлийн дүн	

ДАРГА ( ЗАХИРАЛ ) ( )

НЯГТЛАН БОДОГЧ ( )





